

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017 оны 01 дүгээр сарын 10

Баянхонгор сум

Тус газар нь Монгол Улсын хууль, Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газрын баталсан тогтоол, шийдвэрүүд, Хууль зүйн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, өгсөн үүрэг, зөвлөлийн хурлын шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан тогтоол, захирамж, Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулах, алба хаагчдын шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

**Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас  
гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой  
үүрэг, даалгавар, хөтөлбөр, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх  
ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох.**

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газраас батлан гаргасан Цагдаагийн байгууллагатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг тасгийн дарга, ахлах нарт болон бие бүрэлдэхүүнд цаг тухай бүрт нь хүргэж, шаардлагатай тохиолдолд үүрэг даалгавар, шийдвэрийн талаар сургалт зохион байгуулан Цагдаагийн байгууллагад холбогдох үндэсний хөтөлбөр, дээд газраас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр тус бүр 5-32 заалт бүхий ажил, арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг тус тус гарган биелэлтийг улирал, хагас жилээр гаргаж, холбогдох газар, албадад хүргүүлсэн.

ЦЕГ-ын “Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2016 онд хийх ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэлээр 2 багц 13 заалт бүхий ажил, арга хэмжээний салбар төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангуулах чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласнаар биелэлт 100 хувьтай хэрэгжсэн.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Цагдаагийн газарт хамаарах болон аймгийн Засаг даргаас Цагдаагийн газрын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой

ажил арга хэмжээг төлөвлөн биелэлтийг тооцоход 100 хувьтай хэрэгжиж, 2017 оны үндсэн чиглэлд 6 арга хэмжээ төлөвлөн батлуулсан.

Хоёр. Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилт, зохиосон ажлын талаар

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаатай холбогдуулан Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, үйл ажиллагааны журам, танилцуулгыг алба хаагчдад танилцуулан, гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж холбогдох албадад хүргүүлсэн.

Байгууллага, алба хаагчийн өдөр тутмын ажилд дотоодын хяналтыг тавих, шинэчлэн батлагдсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн цагдаагийн албан хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлыг таслан зогсоох зорилгоор байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар Жинст, Баянхонгор сумын Шаргалзуут 8 дугаар багт улсын төсвийн хөрөнгөөр цагдаагийн хэсгийн байр /кабон/-ыг барих үйл ажиллагааны тендерийг хуулийн дагуу зохион явуулж, уг барилгын ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “Базар дарь” ХХК-тай гэрээ байгуулан, барилгын гүйцэтгэлийн явцад ЦЕГ-аас 1, Цагдаагийн газрын удирдлага бусад албан тушаалтнаас 3 удаа газар дээр нь очиж хяналт тавин ажилласнаар энэ оны 9 дүгээр сард улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулснаар бүх сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар албаны байраар хангагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд баригдах Цагдаагийн газрын конторын шинэ барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, барилга угсаалтын “Хаш голоо” ХХК 1,687,0 сая төгрөгөөр барих төсөвтэйгээр шалгарч, барилгын ажлын гүйцэтгэлд ЦЕГ-ын Хангарт үйлчилгээний хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг, аймгийн Цагдаагийн газрын удирдлагууд, ГХБХБ, МХГ-ын мэргэжилтэнүүдтэй хамтран газар дээр нь ирж, шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллаж, улсын комисс хүлээн авч, энэ оны 09 дүгээр сарын 19-ны өдөр цогцолбор барилгын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумдын цагдаагийн хэсгийн үйл ажиллагаа, албан хэрэгцээнд ашиглах туулах чадвар сайтай автомашины шаардлагатай

байгаа талаар Улсын онцгой комисст хүсэлт уламжилснаар сумын Засаг даргын Тамгын газраас Баян-Өндөр суманд ашиглаж байсан УАЗ-31512, Баян-Овоо суманд УАЗ -31514, Бууцагаан суманд Ланд крузер-80, жижүүрийн шуурхай албанд 2016 онд үйлдвэрлэгдсэн Приус-30, байгууллагын албан хэрэгцээнд Ланд крузер-200, Старекс маркын автомашиныг тус тус шийдвэрлүүлсэн.

Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоо үр дүнгийн талаар

Тус газраас 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэх 6 бүлэг 37 заалт бүхий ажлын төлөвлөгөөг Хууль зүйн сайдын 2016 оны А/187 дугаар тушаалын хавсралтын дагуу гаргаж, удирдлагаар баталгаажуулан тасаг албадуудад хүргүүлж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сар бүрийн 2 дахь долоо хоногийн Пүрэв гарагт “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг угтан тус газар анх байгуулагдсан Бөмбөгөр, Жаргалант сумдад “Монгол цагдаа-95” арга хэмжээг зохион байгуулж, Цагдаагийн байгууллагын түүхэн үүсэл хөгжил, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг иргэдэд сурталчилан ажиллаж, Ерөнхий боловсролын сурагчдад АХА тэмцээн, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд “Гар бөмбөг”-ийн тэмцээн, жолооч нарын дунд уран жолоодлогын тэмцээнийг тус тус зохион явуулсан.

Тайлант хугацаанд “Нээлттэй өдөр” арга хэмжээг Баянхонгор суманд 8, Баянхонгор аймгийн 19 сумдад тус бүр 1, Жаргалант, Бөмбөгөр суманд тус бүр 1 нийт 29 удаа зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр Цагдаагийн газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг иргэдэд сурталчилж, 3850 ширхэг гарын авлага, материал бэлтгэн тарааж ажиллалаа. “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулсан талаар орон нутгийн Баянхонгор, Хонгор, Хөгжлийн ертөнц ТВ10 телевизүүдээр 16 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, иргэдэд үйл ажиллагааг сурталчилсан.

Тус газар нь Замын цагдаагийн газрын Орон нутаг хурдны замын хяналтын хэлтэс, Авто тээврийн үндэсний төв, Албан журмын даатгагчдын холбоо, “Ноёд-Алтай” групптэй хамтран зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүнээс үүдэн гарах хор хохирлыг бууруулах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин

хангуулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Хөдөлгөөний соёл-бидний оролцоо, осолгүй жолооч-жаргалтай гэр бүл” сэдэвт аяныг зохион явуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслийн жолооч, иргэд нийт 350 гаруй хүн оролцсон. Мөн газраас санаачлан “Осолгүй жолооч- жаргалтай гэр бүл” сэдэвт өдөрлөгийн удирдамж боловсруулан газрын даргаар батлуулан 2016 оны 2, 3 дугаар улиралд тус аймгийн 17 суманд зохион явуулж, 2100 орчим хүн оролцсон.

Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгүүдийн ахлах дунд ангийн хүүхдүүдийг хамруулан “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг зохион байгуулж, замын хөдөлгөөний осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа явуулсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Жаргалант, Богд зэрэг 4 суманд “Нээлттэй өдөр” арга хэмжээ зохион явуулж, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн арга хэмжээ 8, хэсэгчилсэн 14 арга хэмжээ зохион явуулж, арга хэмжээний талаар орон нутгийн 3 телевизид 36 удаа мэдээлэл хийж иргэдэд сээрэмжлүүлэг хүргэсэн. Мөн “Эрчим хүч түгээх газар”, “7 дугаар цэцэрлэг”, “Номундалай” ахлах сургууль, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба”, “Чандмань” ХХК, “Онцгой байдлын газар”, “339 дүгээр цэргийн анги”, “Тахарын алба” зэрэг байгууллагуудын ажилтан, алба хаагч нарт сургалт орж, явган зорчигч хүүхдүүдэд гарцаар гарах, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн талаар анхааруулга, санамж 800 ширхэг хэвлүүлэн тараасан.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ судалгаанд дүгнэлт хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр “Шинэ жил”, “Сар шинэ”, “Хяналт шалгалт”, “Архи”, “Хэсэг”, “Тулгалт 2”, “Хамгаалах бүс”, “Албан мэдэгдэл”, “Бодис”, “Хяналт”, “Захиргааны хяналтын 45 хоногийн аян”, “Оюутан тээвэр”, “Цохилт”, “Эх үрсийн баяр” “Илрүүлэлт-оргодол”, “Шийдвэрлэлт-2016”, “Хяналт-Шалгалт” зэрэг 44 удаагийн ерөнхий болон тусгай арга хэмжээнүүдийг удирдамж, төлөвлөгөөний дагуу тасаг албадууд хамтран зохион явуулж, биелэлт, үр дүнг тухай бүр тооцож, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэдэд сурталчилсан.

Тус газраас 2016 онд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар 112 албан мэдэгдэл хүргүүлж, 94 албан мэдэгдлийн хариуг авч, биелэлт үр дүнг нь

тооцон ажилласан. Тайлант хугацаанд “Албан мэдэгдэл” хэсэгчилсэн арга хэмжээг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагтай хамtran зохион байгуулж, албан мэдэгдлийн хариуг авах, үр дүнг тооцох ажлыг эрчимжуулэх чиглэлээр хэсгийн байцаагч, багийн цагдаа наарт үүрэг чиглэл өгсөн.

Энэ хугацаанд 2 удаа аймгийн ГХУСАЗЗөвлөл болон хуулийн байгууллагуудтай хамtran аймгийн 19 сумын 104 багийн давхардсан тоогоор 4530 орчим иргэд, олон нийтэд шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжуудыг тайлбарлан таниулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 3820 ширхэг гарын авлага тараах материалыг бэлтгэн тараасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд, Голомт, Хаан банкны ажилчид, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Төрийн банк зэрэг албан байгууллагуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, яриа ухуулга, мэдээлэл хийж ажиллав.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Баянхонгор”, “Хонгор”, “Хөгжлийн ертөнц ТВ10”, аймгийн хэвлэл мэдээллийн алба зэрэг телевизүүдэд долоо хоног бүр мэдээлэл хийж, үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 56 удаагийн ярилцлага өгч иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлгийг нэвтрүүлсэн.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамtran ажилладаг хууль, хяналтын 8 байгууллагуудтай хамtran ажиллах “Санамж бичиг”-ийг 2016 оны 02 дугаар сард байгуулан, биелэлт үр дүнг улирал бүр тооцон ажилласан.

Тус газраас гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дугаартай “Нийтийн эргүүл”-ийг ажиллуулах тухай захирамжийг гаргуулж, Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудыг хуваарыт оруулан 50 аж ахуйн нэгж, байгууллагын 246 алба хаагч, ажилтнуудыг “Нийтийн эргүүл”-д гарган ажиллуулсан. Эргүүлээр аж ахуй нэгж, байгууллага, иргэн, тээврийн хэрэгсэлд цагдаагийн албан хаагчидтай хамtran хяналт шалгалтыг явуулж ажилласан ба давхардсан тоогоор 159 аж ахуй нэгж байгууллага, 275 иргэн, 769 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг явуулсан.

Баянхонгор аймаг дахь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн захиргаатай хамтран дээд сургуулийн хичээлийн байрны орчим гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, оюутан залуусыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор 2016 оны 7 дугаар сард “Оюутан цагдаа” арга хэмжээг хэрэгжүүлсэн. Арга хэмжээний хүрээнд Худалдаа үйлдвэрлэлийн сургуулийн 20 оюутан цагдааг баяр наадмын үеэр цагдаагийн алба хаагчидтай хамтарсан хамгаалалт, эргүүлийн үүргийг гүйцэтгүүлсэн. Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байгаа талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага өгч, иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилсан.

**Дөрөв: Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр**

Тус газраас архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор “Архи”, “Хэсэг”, “Хяналт”, “Цохилт”, “Урьдчилан сэргийлэлт 2016”, “Зөрчлийн илрүүлэлт”, “Шинэ жил” ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдал бүрт хуулийн хариуцлагыг хүлээлгэж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр 16 удаагийн ярилцлага өгч, арга хэмжээний зорилго, үр дүнг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан. Архидан согтуурахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр архидан согтуурч, ахуйн хүрээнд хэрүүл маргаан үүсгэж, гэр бүлийн хүчирхийлэл дарамт учруулдаг 20 иргэнийг судалж, “Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, хөдөлмөр хийлгэх газар”-т 3-6 сарын хугацаанд албадан эмчилгээнд хамруулсан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас албадан эмчилгээний болон хуяглан хүргэх 4.725.000 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлсэн. 2016 онд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн 47 аж ахуйн нэгж, иргэнийг 2.040.000 төгрөгөөр торгож, удаа дараа зөрчил гаргасан 1 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналтай аймгийн Хууль зүйн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Баянхонгор сумын Номундалай, Эрдэм, Эрдэнэмандал, Номгон, Хаан банк, Баянхонгор эрчим хүч зэрэг байгууллагуудад архины хор хөнөөлийн талаар 1 цагийн сургалтыг явуулж, хэвлэл мэдээллийн 3 телевизид архидан согтуурахтай тэмцэх, хор хөнөөл, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаваруудын талаар 12 удаагийн ярилцлага өгч, “Баянхонгор таймс” сонинд 2 мэдээлэл өгч иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг өгч ажилласнаар саатуулагдсан хүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 679 нэгжээр буюу 28,6 хувиар буурсан.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран архи, тамхигүй орчин бүрдүүлсэн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг шалгаруулах 1

сарын аяныг зохион байгуулж, нэгдсэн дүнгээр эхний байранд шалгарсан 3 байгууллагын хамт олныг шагнаж, аяны хүрээнд хийсэн ажлын талаар орон нутгийн 3 төлөвистэй хамтран иргэдэд мэдээлэл өгч, үйл ажиллагааг сурталчилсан.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласны үр дүнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 113 бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 11,8 хувиар өсч, шүүхийн шийтгэврээр баривчлагдсан иргэн 97 буюу урд оны мөн үеэс 78 хувиар буурсан.

Шүүхийн шийдвэрээр баривчлагдсан этгээдэд орох сургалтын хуваарийг Цагдаагийн газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу сургалт зохион явуулах талаар холбогдох алба хаагчдыг шаардаж, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” “Харуусал” “Осол”, “Архины хор хөнөөл, архи хүний бие махбодид хэрхэн нөлөөлөх нь”, “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Тамхины хяналтын тухай хууль”, “Саатуулах байрны дотоод журам”, “Захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлэх журам”, “Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль” шинэчилсэн найруулга зэрэг сэдвээр нийт 236 удаа сургалт зохион явуулж, давхардсан тоогоор 320 хүн хамрагдсан.

Гудамж талбай олон нийтийн газар, биеэ авч явах чадваргүй, ухаангүй унасан, очих газраа мэдэхгүй болсон 215 хүний хаягийг тогтоож ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажиллав.

#### Тав. Олон нийт – Цагдаагийн хамтын ажиллагааны чиглэлээр

Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр бүх сумдад аймгийн ГХУСАЗЗ, бусад хуулийн байгууллагуудтай хамтран 2 удаагийн хууль сурталчлах аяныг зохион байгуулж, иргэдэд яриа ухуулга хийж, үйл ажиллагаагаа сурталчилж ажилласан.

Тус газраас “Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 257 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр аймгийн төв Баганат талбайд “Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийг зохион байгуулсан. Өдөрлөг арга хэмжээнд 250 орчим иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүд оролцож, тус газраас Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг Цагдаагийн газрын түүхийн товч танилцуулга, цагдаагийн бэлэгдэл “Цагаан шонхор”-ын баримтат кино, 2015, 2016 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн онцлог ажлын тайланг төв талбайд байрлах LED дэлгэцээр үзүүлж

иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилсан. “Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны өдөр” өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд Баянхонгор суманд оршин сууж, ажил хөдөлмөр эрхэлдэг 120 иргэнээс санал асуулгын хуудас бөглүүлэн авч, дүнг нэгтгэн холбогдох албанд хүргүүлж ажилласан.

Тус газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрлийн зурагт хуудас, сээрэмжлүүлгийг бэлтгэж, “Нээлттэй өдөр”, өдөрлөг арга хэмжээ бусад хуулийн байгууллагуудын хамтарсан нийтийг хамарсан арга хэмжээний үеэр нийт 1860 ширхэг зурагт хуудас, сээрэмжлүүлгийг иргэд олон нийтэд тарааж ажилласан. Мөн Цагдаагийн ерөнхий газраас болон Нийтийн хэв журам хамгаалах албанаас ирүүлсэн богино хэмжээний видео, шторкууд болон тус газраас хийсэн 3 төрлийн шторкыг аймгийн төв талбайн LED дэлгэцээр иргэдэд үзүүлж, иргэдэд анхааруулга, сээрэмжлүүлэг өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа Олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг мэргэшүүлэх сургалтыг 2016 онд 4 удаа зохион байгуулж, хийсэн ажлын дүн мэдээг авч, үүрэг чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиг үүрэг бүхий 28 Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшууллын зардалд 64.512.000 төгрөг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн.

Зургаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж,  
бусад хууль сахиулах болон нутгийн төр, захиргааны  
байгууллагуудтай хамтран ажиллах

Тус газрын жижүүрийн шуурхай албанд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, мэдээлэл иргэдээс ирүүлсэн дуудлаганд шуурхай очиж, асуудлыг шийдвэрлэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээж авах дэвтэр”-т бүртгэж, хариуцсан албан тушаалтнууд шийдвэрлэн ажиллаж, 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 119 гомдол, мэдээлэл хүлээн авч, 38 эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад 15 нэгжээр буюу 65,2 хувиар өссөн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, түүний харьяа агентлагууд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Боловсрол, соёлын газрын насан туршийн боловсролын төв, Баянхонгор сумын ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтнууд, Эрүүл мэндийн газар, Монголын Залуучуудын холбоо, Дэлхийн ЗӨН-Баянхонгор I, II, ОНХХ зэрэг байгууллагуудтай хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ” чуулганыг бүх сумдад зохион

байгуулсан ба чуулганд оролцсон төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, нийт 1940 орчим ажилтан алба хаагчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулан ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 82 этгээдүүдийн судалгааг хэсгийн байцаагч нараар гаргуулж, 1 удаа 4 цагийн сургалтыг зохион байгуулж ажиллав. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд өөрийгөө болон бусдыг гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирохоос хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт хийж, мөн сурталчилгаа, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон LED телевиззээр хүргэж ажилласан. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд алба хаагчдыг түргэн шуурхай очиж хуулийн дагуу хойшлуулшгүй ажиллагааг бүрэн дүүрэн хийж, бүх талаас нь шалгах, хохирогчийг хамгаалах, түүнд тусlamж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байгаад удирдлагаас өдөр тутам хяналт тавьж ажилласан.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажилд орон нутгийн удирдлага, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран "Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн түншлэлийн багийн ажлын үр дүн, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" аймгийн гуравдугаар зөвлөгөөнийг 2016 оны 4 дүгээр сард зохион байгуулж, зөвлөгөөнд Баянхонгор аймгийн 19 сум, 9 багийн 7 хүний бүрэлдэхүүнтэй "Нийгмийн түншлэлийн баг"-ууд оролцож, "Гэр бүлийн үнэ цэнэ" сургагч багш бэлтгэх 5 багц хичээлийн сургалтад хамрагдсан.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн гомдлыг хүлээн авч гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, ахуйн хүрээнд архидан согтуурч, танхайрсан 1766 иргэнийг захиргааны журмаар албадан saatuулж, шалтгаан нөхцөлийг тогтоон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 93 хүнийг шүүхээр баривчлуулж, архидан согтуурч, ахуйн хүрээнд удаа дараа танхайрч, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, гэр бүлийн гишүүдээ айдас түгшүүртэй байдалд байнга оруулдаг хүмүүсийн судалгааг гаргасан.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Баянхонгор Дэлхийн ЗӨН, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Завхан, Баянхонгор аймгуудын Хангайн бүсийн "Хүүхдэд ээлтэй орон нутаг-хүүхдийн оролцоо" сэдэвт туршлага солилцох

чуулганыг аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран 2016 оны 09 дүгээр сарын 15-наас 18-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Долоо: Захиргааны хяналтын чиглэлээр

Шүүхээр ял шийтгүүлж, аймгийн прокурорын газраас цагдаагийн байгууллагад хяналт тогтоолгохоор ирүүлсэн хорих ял нь тэнсэгдсэн 68 ялтан, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 14, ял хойшлогдсон 9 ялтан нийт 91 этгээдийн шийтгэх тогтоолыг хүлээн авч нэгдсэн бүртгэлд авч холбогдох алба хаагч нарт захиргааны хяналт тогтоолгохоор шилжүүлэн өгч мэдээллийн санд оруулсан. Аймгийн Прокурорын газрын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд захиргааны хяналтанд байгаа этгээдүүдийн хувийн хэргийг 7 удаа прокурорт бүрэн хянуулж, зөрчилгүй шалгагдаж, эрх бүхий алба хаагчдад нийт 38 ажлын зааварчилга өгч, мэргэжлийн удирдлагаар хангасан.

Захиргааны хяналт тогтоох эрх бүхий алба хаагчдад нийт 42 ажлын зааварчилга өгч, мэргэжлийн удирдлагаар хангасан. УЕП, ЦЕГ-ын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн A/05, A/09 тушаалаар “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-ыг баталсан тул алба хаагчдад танилцуулан судлуулж, үйл ажиллагаандaa хэрэгжүүлж байна. Аймгийн Прокурорын газартай хамтран эрх бүхий алба хаагчдад 2 цагийн сургалтыг зохион явуулсан.

Аймгийн хэмжээнд захиргааны хяналтанд байгаа хорих ял эдлээд суллагдсан зарим хүмүүст тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 2016.03.28-ны өдрөөс эхлэн 45 хоногийн аяныг зохион байгуулан ажиллаж, сумдын хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлэн, захиргааны хяналтанд байгаа иргэдийг цуглуулж, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх чиглэлээр сургалт явуулж, санал хүсэлтийг нь сонссон. Мөн ажлын байраар хангах нийгэмшүүлэх чиглэлээр аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран сургалт авч, холбогдох судалгааг хүргүүлэв.

Найм. Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр

ЦЕГ-ын даргын 2016 оны баталсан “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах талаар 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тус газраас 7 бүлэг 34 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж, биелэлт 98,9 хувьтай. Байгууллагын албаны нууцлал, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар 2 удаа гэнэтийн

шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг удирдлагад танилцуулан, зөрчлийг арилгах чиглэлээр зааварчилгаа өгсөн.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ЦБУАЖ-ын “Дотоод аюулгүй байдлыг хангах” /код 113/ 113-д заасан журмын талаар гарын авлага бэлтгэн, алба хаагч нарт судлуулан хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 4 удаа 4 цагийн, “Байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зөвлөмж” “Барилга байгууламжийн аюулгүй байдал”, “Санхүүгийн аюулгүй байдал”, “Хүний нөөцийн аюулгүй байдал”, “Галт зэвсэгтэй харилцах тактик, ажиллагаа”, “Галт зэвсэг хадгалах, олгох”, “Галт зэвсэг тээвэрлэх”, “Галт зэвсэг хэрэглэх” сэдвээр сургалт зохион байгуулж, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт албан бичгээр зааварчилгаа өгч, биелэлт үр дүнг нь тооцон ажилласны үр дүнд мэдээлэл алдагдсан зөрчил гараагүй.

Мөн алба хаагчийн эрх чөлөөнд халдсан, хууль ёсны шаардлагыг нь эсэргүүцсэн, ажил үүрэгтэй нь холбогдуулан өөрийг нь болон гэр бүлийн гишүүдийг нь доромжилсон, заналхийлсэн үйлдэл бүрийг тусгайлан бүртгэлд авч, тухай бүр удирдлагад танилцуулан шуурхай шалгуулах, бүртгэгдсэн тохиолдол бүрийг тухайн өдрийн ёс журмын эргүүлүүд хяналт тавьж, нөхцөл байдлыг баримтжуулах, тасгийн дарга нар алба хаагчидтайгаа уулзаж, ажлын зааварчилга, зөвлөгөө өгч, албаны итгэл үнэмшил олгох сэтгэл зүйн ярилцлага хийж байх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авсан.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас 2016 онд ирүүлсэн 2/86, 4/311, 4/182 дугаартай ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 5-12 заалт бүхий төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавьж, ЦЕГ-ын тэргүүн дэд даргын 2016 оны 2/138, дэд даргын 2016 оны 4/376, 4/1709 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийг алба хаагчдад танилцуулан, хэрэгжүүлэх чиглэлээр 186 алба хаагчаас бичгээр баталгаа гаргуулан ажилласан.

Орон тооны бус ажлын хэсэг энэ онд нийт 5 удаа хуралдаж, байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлын эрсдэлд дүгнэлт хийж, цаашид ажиллах чиглэл, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хэлэлцсэн. Цагдаагийн газрын шинэ байр баригдсантай холбогдуулан алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын гадна болон дотор талд нийт 19 ширхэг камер байрлуулж хадгалах төхөөрөмжийг серверийн өрөөнд байрлуулсан. Мөн галын дохиолын нэгдсэнг системыг давхар бүрийн өрөө, коридор, автомашины гражид суурилуулж, хяналтын дэлгэцийг жижүүрийн шуурхай албаны өрөөнд байрлуулсан. Галын хорыг давхар бүрт тавьсан. Байгууллагад учирч болох эрсдэл, хүний нөөц, үйл ажиллагааны

талаарх арга хэмжээг тухай бүр газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, үр дүнг тооцон ажиллаж хэвшсэн.

ЦЕГ-ын даргын тушаалаар тус цагдаагийн газарт албан үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг “МИГ даатгал” ХХК-ны даатгалд хамруулж, нийт 130 алба хаагчдыг 3,2 сая төгрөгөөр даатгуулсан.

Ес. Тасаг, албадын үйл ажиллагааны талаар

1.Хүний нөөцийн ажлын чиглэлээр:

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын орон тоо нь ЦЕГ-ын даргын 2015 оны 313, 399, 2016 оны Б/61 дүгээр тушаалаар батлагдсан офицер 71, ахлагч 65, энгийн 3, гэрээт цагдаа 4 нийт 143 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 2016 онд офицер 70, ахлагч 64, энгийн 3, Монголбанкны гэрээт 4, нийт 141 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Батлагдсан орон тооноос сэтгэл зүйчийн 1 орон тоо дутуу байна.

Цагдаагийн газрын батлагдсан орон тооны ахлагчийн дутуу орон тоонд нөхөн хангалт хийх, нөөц бүрдүүлэх зорилгоор тус газарт ажилд орохоор хүсэлт гаргасан дээд боловсролтой, эрх зүйч болон бусад мэргэжилтэй иргэдийг бүртгэн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”/код 901/-д заасны дагуу судлан, шаардлага хангасан 29 иргэний холбогдох материалыг Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу ахлагчийн сул орон тоонд өрсөлдүүлэн сонгон авах мэргэшлийн шалгалтад хамруулан, тэнцсэн 12 иргэнийг Цагдаагийн мэдлэг олгох анхан шатны дамжаанд хамруулсан.

Байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг ханган тус газрын сул орон тоонд өрсөлдөх иргэдийг бүртгэх, нөөцөд авах талаар аймгийн “Хөгжлийн ертөнц” TY-10 телевизээр тухай бүр, мөн газрын иргэдийн хүлээлгийн танхимд байрлах байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн мэдээллийн самбар, байгууллагын вэб сайт болон албан ёсны фэйсбуүк хаягаар зарлан мэдээлж сул орон тооны сонгон шалгаруулалтад оролцох иргэдийн нөөцийг ил тод байдлаар бүрдүүлэн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”/код 901/-д заасны дагуу судалгааг хийн ажилласан.

2015 оны 09 дүгээр сар, 2016 оны 02 дугаар сард зохион байгуулагдсан мэргэшлийн шалгалтад тэнцэж, цагдаагийн анхан шатны мэдлэг олгох мэргэжлийн

дамжааг дүүргэсэн иргэдээс Цагдаагийн газрын даргын тушаалаар нийт 12 иргэнийг тус тус томилуулсан.

Албан тушаал өөрчлөх хүсэлт гаргасан 17, шилжин ажиллах хүсэлт гаргасан 6, шинээр томилогдсон 7, албан тушаал дэвшин томилогдох хүсэлт гаргасан 6, цэргийн байнгын тэтгэвэрт гарахаар албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 2, ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн албан тушаал бууруулж томилуулах 2, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөх 1, төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулах 1, чөлөө олгуулах 1, гучин сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгуулах 3, газрын даргын тушаалаар чөлөө олгосон 36, 1-3 хоногийн чөлөө олгосон 41, ЦЕГ-ын Сургалт, дадлагын төвд болон бусад сургалтад хамрагдсан 56, өвчний учир эмнэлгийн магадлагаа олгогдсон 45, сахилгын шийтгэл ногдуулсан 36, хугацааны цол олгосон 7, шагнасан 66 нийт 333 мэдээллийг хүний нөөцийн цахим санд шивж, баяжилт хийсэн.

ЦЕГ-ын даргын тушаалаар томилогдсон 12 алба хаагчийн ажлыг хүлээлцүүлэн мэдэгдлийн хариуг хүргүүлж, тус газрын бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах үндэслэл бүхий саналыг боловсруулан, ЦЕГ-ын ХНСХ-т хүргүүлэн Жаргалант, Бууцагаан сум дахь Сум дундын цагдаагийн хэсгийг “Тасаг” болгон шийдүүлэн, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Энэ онд нэгдсэн үнэмлэх солилтоор 133 алба хаагчдад албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг шинээр болон өөрчлөн олгож, захиргааны чөлөө, ээлжийн амралт, ажил өөрчлөх, албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэх, ажилд орох, суралцах хүсэлт гаргасан 345 алба хаагч, иргэдийн өргөдлийг хүлээн авч, удирдлагын цохолтын дагуу шийдвэрлэж, хариуг хугацаанд нь өгч ажилласан.

Тус газарт ажиллаж байгаа алба хаагчдаас цагдаагийн хурандаа 1, дэд хурандаа 5, хошууч 12, ахмад 14, ахлах дэслэгч 21, дэслэгч 16, ахлах ахлагч 28, ахлагч 20, дэд ахлагч 16 байгаа бол 21-25 хүртэлх насыны офицер 15, ахлагч 14, 26-30 хүртэл насыны офицер 16, ахлагч 20, 31-35 хүртэл насыны офицер 17, ахлагч 11, ТҮ энгийн 1, 36-40 хүртэл насыны офицер 11, ахлагч 8, 41-45 хүртэл насыны офицер 10, ахлагч 9, ТҮ энгийн 2, 46-50 хүртэл насыны офицер 2 алба хаагч тус тус байна.

Ажилласан жилийн хувьд 1 жил хүртэл офицер 2, ахлагч 8, 1-5 жил хүртэл офицер 16, ахлагч 22, 5-7 жил хүртэл офицер 4, ахлагч 6, 8-10 жил хүртэл офицер 14, ахлагч 13, 11-15 жил хүртэл офицер 18, ахлагч 9, 16-20 жил хүртэл офицер 9, ахлагч 5, 21-25 жил ажилласан офицер 7, ахлагч 1, ТҮ энгийн 2 алба хаагч байгаа

бол бие бүрэлдэхүүний 105 алба хаагч буюу 77.2 хувь нь дээд, 4 буюу 2.9 хувь нь тусгай дунд, 22 алба хаагч буюу 16.1 хувь нь бүрэн дунд боловсролтой, 4 алба хаагч буюу 2.9 хувь нь магистрын зэрэгтэй алба хаагч байна.

## 2. Алба хаагчидтай ажилласан байдал

2016 онд газар, тасгийн дарга, ахлах байцаагч нараас хариуцсан алба хаагч нартайгаа ганцаарчилсан болон хэсэгчилсэн байдлаар 126 алба хаагчидтай 45 удаа уулзалт, 11 удаа сургалт зохион байгуулж, 63 удаа зөвлөгөө зөвлөмж, зааварчилгаа өгч, алдаа дутагдал гаргасан 36 алба хаагчтай ганцаарчлан уулзаж, ярилцан зөвлөгөө өгч, алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, 16 алба хаагчийг өвдөхөд нь эргэж, гачигдал тохиолдсон болон амьдрал ахуйд нь сэтгэл санаа, эдийн буюу мөнгөн туслалцаа үзүүлж, давхардсан тоогоор 47 алба хаагчийн ажлыг шалган зааварчилж, 45 алба хаагчдад үүрэг, даалгавар өгч биелэлтийг нь тооцон ажилласан. Мөн сахилга ёс зүйн зөрчил гаргасан 36, гэр бүлийн асуудалтай байгаа 4, нийт 40 алба хаагчид болон тэдний гэр бүлийн 9 гишүүдтэй тус тус уулзаж, мэдээлэл аван, сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж дэмжлэг үзүүлсэн.

Байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гадны болон дотоодын шалгалтаар илрүүлсэн зөрчилд давхардсан тоогоор 60 алба хаагчдад холбогдуулан тасаг, хэсгийн дарга нараас 40 удаа албаны шалгалт явуулан, газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлж, нийт 36 алба хаагчдад гаргасан зөрчлийн шинж чанарт тохирсон сахилгын шийтгэл ногдуулж, дахин алдаа зөрчил гаргахгүй байх чиглэлээр тасгийн дарга нарт үүрэг чиглэл зааварчилгаа өгсөн.

Газрын даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу албан тушаал өөрчлөх, дэвшүүлэх, бууруулах, шагнуулах саналтай 47 алба хаагчийн материалыг холбогдох газруудад хүргүүлсэн. Тус газрын бие бүрэлдэхүүнд хөдөлгөөн орсонтой холбоотойгоор нийт 134 алба хаагчдын дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн гаргаж, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэтгэмж, дэмжлэг тусламж үзүүлэхэд ашиглаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 42 алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулж, бүх төрлийн нарийн шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулан, эмчилгээ шаардлагатай 7 алба хаагчийг эмнэлэгт хэвтүүлэн 5 алба хаагчийг гадуур эмчлүүлсэн.

## 3. Албаны сургалтын талаар

Тус газар нь 2016 онд зохиогдох албаны сургалтын нэгдсэн болон сэдэвчилсэн төлөвлөгөөг, тасаг бүр албаны сургалтын хуваарь гарган батлуулж, нийт бие

бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн “Мягмар” гарагт онолын, “Баасан” гарагт бие бялдарын бэлтгэлжилтийн сургалтыг нэгдсэн байдлаар, тасгууд төрөл мэргэжлийн чиглэлээр долоо хоног бүрийн хуваарьт өдөр сургалтыг зохион явуулж хэвшсэн.

Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор 2016 оны 01 дүгээр сард 6 асуулт бүхий санал асуулгыг алба хаагчдаас авч нэгтгэн, удирдлагад танилцуулан санал асуулгын дүнд үндэслэн 2016 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулж, ЦЕГ-ын даргын 2016 оны б/106 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу энэ онд сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг тасгуудаас авч, нэгтгэн баталгаажуулж, ЦЕГ-ын Сургалтын төвд хүргүүлсэн.

Газрын даргаас 2016 онд баталсан сургалтын хөтөлбөр, цаг, сэдэв төлөвлөгөөний дагуу нэгдсэн хичээлээр алба хаагчдыг хөгжүүлэх 15 удаагийн 30 цагийн сургалтад давхардсан тоогоор 1170 алба хаагчдыг, мэдвэл зохих хууль тогтоомжийн 28 удаагийн 56 цагийн сургалтад давхардсан тоогоор 2184 алба хаагчдыг, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах 15 удаагийн 30 цагийн сургалтад давхардсан тоогоор 1170 алба хаагчдыг хамруулсан.

Тасгийн даргаас дээш албан тушаалтан заасан хичээлд албаны шалгалт явуулах журмаар 5 тасгийн дарга наарт 1 удаагийн 30 минутын сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн 15 удаагийн сургалтыг төлөвлөснөөс 15 сургалтыг зохион байгуулж үнэлгээ нь 100 хувь, мэдвэл зохих хууль тогтоомжийн 11 удаагийн сургалтыг төлөвлөснөөс 28 сургалтыг зохион байгуулж үнэлгээ 100 хувь, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах 5 удаагийн сургалтыг төлөвлөснөөс 15 сургалтыг зохион байгуулж үнэлгээ 100 хувь, бие бялдарын бэлтгэлжилтийн түвшин дээшлүүлэх 24 удаагийн сургалтыг төлөвлөснөөс 48 удаагийн сургалтыг зохион байгуулж үнэлгээ 100, сургалтын хэрэглэгдэхүүн, кабинет, төсөв 99 хувьтай.

Байгууллагын “Үйл ажиллагааны хэт /бизнес-/ийн төлөвлөгөө /2013-2016 он/, “Хөгжлийн стратеги хөтөлбөр” /2013-2021 он/-т алба хаагчдын албаны, мэргэжлийн болон давтан сургалтад бүрэн хамруулан, тэдний гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, ажил хариуцах чадвар, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах зорилтыг тавин, тухайн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн, үр дүнг нь тооцон ажиллав.

Энэ хугацаанд албаны сургалтын зардалд нийт 208500 төгрөгийг зарцуулснаас худалдан авах ажиллагаанаас зохион байгуулсан сургалтад

хамрагдсан 2 алба хаагчийн сургалтын төлбөр 70000, мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрх сунгах 21 хоногийн сургалтын төлбөрт 96800, Архивын ерөнхий газрын сургалтад хамрагдсан алба хаагчид 41700 төгрөгийг тус тус зарцуулсан.

Алба хаагчдыг дэвшүүлэн томилох, гадаад, дотоодод суралцуулах, шагнал урамшуулалд тодорхойлохдоо Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 909, 924/-д заасан үндэслэл журмын баримтлан сахилга ёс зүйн зөрчил гаргасан байдал, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрхэн гүйцэтгэж байгаа байдлыг харгалзан шалгуур үзүүлэлт болгон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж хэвшилсэн. Энэ оны байдлаар ЦЕГ-ын даргын 2016 оны б/106 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Сургалт, дадлагын төвд зохион байгуулагдсан сургалтад 44, Хууль сахиулах их сургуулийн эчнээ сургалтад 3, ХСИС-ийн магистрын сургалтад 1, ЦЕГ-аас ХСИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн гадаад хэлний сургалтын төвтэй хамтран зохион байгуулж буй Англи хэлний сургагч багшийн болон дунд, гүнзгий шатны сургалтад тус бүр 4, ГА-ын эрх олгох сургалтад 4 алба хаагчийг нийт 56 алба хаагчийг тус тус хамруулсан. Мөн “Улаанбаатар Эрдэм-Судлал” дээд сургуулийн эчнээ эрх зүйн ангид 17 ахлагчийг дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй болгох зорилгоор сургалтын гэрээ байгуулан сурх нөхцөл боломжоор нь хангасан.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газраас “Орхон” их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан 2015-2016 оны хичээлийн жилд 28 алба хаагчийг магистрантрын сургалтад хамруулах ажлыг орон нутагтаа зохион байгуулж, 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Хууль зүйн магистрын зэрэг олгох шалгалтад амжилттай хамрагдаж, хууль зүйн ухааны магистрын болзол хангасан.

БНСУ-ын Сөүл хотын Галын Академид “Эрэн хайх, аврах ажиллагаа, эмнэлэгийн анхан шатны тусlamж үзүүлэх дадлага” сэдэвт 10 хоногийн сургалтад 7 алба хаагчийг суралцуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдын бие бялдарын бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх зорилгоор 6-10 саруудад долоо хоног бүрийн “Бямба” гарагт нийт алба хаагчдыг 1-3 километрийн зайд тогтмол алхуулан, “Даваа” гараг бүрийн 19.00-21.00 цагийн хооронд аймгийн спорт зааланд тодорхой төрлийн спортоор хичээллүүлж хэвшилсэн.

ЦЕГ-ын даргын 2016 оны Б/302 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагч ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын ажиллах урам зориг, ар гэртээ зарцуулах цаг завыг нэмэгдүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “БИД ЦАГДААГИЙН ГЭР БҮЛ” сэдэвт арга хэмжээг батлагдсан удирдамжийн дагуу 2016 оны 10 дугаар сард Цагдаагийн газрын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд алба хаагчдын гэр бүлийн гишүүд оролцсон.

Дээрх арга хэмжээний үеэр гэр бүлийн гишүүдэд Цагдаагийн газраас хийж хэрэгжүүлж буй онцлог ажлуудын талаар зурган тайланг танилцуулж, тэдний сэтгэл зүйн мэдлэг, мэдээлэл болон гэр бүлийн харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотоос “Эрэгтэйчүүд, эрүүл гэр бүл” ТББ-ын сургагч багш М.Цасцихэрийг урьж “Гэр бүлийн харилцаа, хандлага, үнэт зүйл” сэдэвт 1 удаагийн 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Уулзалт, ярилцлаганд ирсэн гэр бүлийн гишүүдийн дунд халуун дулаан уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор З төрлийн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, үүний дараа Цагдаагийн газрын удирдлагууд тэдний санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авсан.

#### 4. Соён гэгээрүүлэх ажлын талаар

Цагдаагийн алба хаагчдын чөлөөт цагийг гэр бүлийн гишүүдийн хамт зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлдээ цаг зав зарцуулах, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Соён гэгээрүүлэх ажил зохиох” журам /код 940/-ын 940.2.1-д заасны дагуу газрын бие бүрэлдэхүүний дунд соёлын үйл ажиллагаа явуулах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллалаа.

Алба хаагчдын ерөнхий мэдлэгийн төвшинг дээшлүүлэх, өөрийгөө бусдад илэрхийлэх, ярих, илтгэх урлагийг эзэмшүүлэх, аливаа мэдээллийг олж, дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх зорилгоор өглөө бүрийн шуурхай яриан дээр дотоодын болон гадаад орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг, танин мэдэхүйн бусдад мэдээлэл, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээллийг хуваарь гарган алба хаагч нэг бүрээр хийлгэх ажлыг хэвшил болгон явуулснаар тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 504 алба хаагчдаас дээрх чиглэлийн мэдээллийг хийжээ.

Алба хаагчдыг сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, стресс, бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх мэдлэгийг олгуулах зорилгоор алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдэд Хүний хөгжлийн институтын лектор багш Найданг урьж “Чи одоогийн ханьтайгаа дахин гэрлэхийг хүсч байна уу” лекц, түүхч Б.Өлзийбаатараар “Монголын түүх” лекцүүдийг уншуулсан нь албандаа итгэх итгэл, урам зоригийг сэргээх чухал үйл явдал болсон.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг угтаж, тус газраас санаачлан “Бүтээлч ажил-95” аяныг өрнүүлэн 95 бүтээлч ажил, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө гарган, Цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан 12 төрлийн арга хэмжээнд оролцож, 2 төрөлд тэргүүн байрт шалгарсан. Цагдаагийн газрын зохион байгуулсан 68 төрлийн арга хэмжээнд алба хаагчдыг гэр бүлийн гишүүдийн хамт оролцуулж, урамшуулсан.

Цагдаагийн алба хаагчдын чөлөөт цагийг гэр бүлийн гишүүдийн хамт зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлдээ цаг зав зарцуулах, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон “Соён гэгээрүүлэх ажил зохиох” журам /код 940/-ын 940.2.1-д заасны дагуу газрын бие бүрэлдэхүүний дунд спорт, урлаг соёлын 12, Цагдаагийн байгууллага болон орон нутгаас зохион байгуулсан спорт, урлагийн 16 арга хэмжээнд оролцсоноос аймгийн аварга шалгаруулах “Явган аялал”, “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнд “Тэргүүн” байр, Зэвсэгт хүчний 95 жилийн ойн арга хэмжээний хүрээнд аймгийн хууль, хүчний байгууллагуудын дунд зохион байгуулсан 5 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр тэргүүн байрт шалгарч “Шилжин явах цом”-оор шагнуулсан.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Шатар”-ын тэмцээнд хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч М.Саранцэцэг түрүүлж, Алтан медаль, мөнгөн шагналаар шагнуулсан.

Хангайн бүсийн цагдаагийн газрын алба хаагчдын дунд “Урлаг спортын наадам”-ыг урлагийн 5, спортын 3 төрлөөр энэ оны 5 дугаар сард Баянхонгор аймагт зохион байгуулж, нийлбэр дүнгээр тус газрын алба хаагчид тэргүүн байрт шалгарсан.

##### 5. Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас 2016 онд ирүүлсэн 2/86, 4/311, 4/182 дугаартай ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 5-12 заалт бүхий төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавьж ажилласан. ЦЕГ-ын тэргүүн дэд даргын 2016 оны 2/138, дэд даргын 2016 оны 4/376, 4/1709

дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийг алба хаагчдад танилцуулан, хэрэгжүүлэх чиглэлээр 186 алба хаагчаас бичгээр баталгаа гаргуулан авч ажилласан.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр 2016 онд сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг тус байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүд 4 удаа зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 6 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Байгууллагын даргын 2008 оны 11 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр өдөр бүр тасгийн дарга, ахлах алба хаагчдаас ёс журмын эргүүлд томилон гаргаж, алба хаагчдын цаг ашиглалт, эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэлт, иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдолын шалгалт шийдвэрлэлтэнд 7 хоног бүр хяналт тавин ажилласан.

Газрын хэмжээнд 2016 онд сахилгын шийтгэл хүлээсэн 36 алба хаагчдын дэлгэрэнгүй болон хураангуй мэдээг сар, улирал, хагас жилээр гарган, ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлсэн.

2016 онд тус газрын бие бүрэлдэхүүнээс нийт давхардсан тоогоор 99 алба хаагчид шагнагдаж, давхардсан тоогоор нийт 36 алба хаагч сахилгын зөрчил гарган арга хэмжээ авагдсанаас офицер 30, ахлагч 6 байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчид нийт бие бүрэлдэхүүний 25.3 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 4 нэгжээр буюу 10 хувиар буурсан.

Сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрээр авч үзвэл ЦАХ-ийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн 4, ажлын хариуцлага алдсан 12, ЭБШХ болон бусад хууль дүрэм зөрчсөн 9, ЦАХ-ийн ёс зүйн дүрмийг зөрчсөн 1, архидан согтуурсан 8, бусад 2 зөрчил байна. Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлөөр нь авч үзвэл хувь хүний буруутай үйл ажиллагаа 26, хяналт шалгалт сул 4, хууль дүрэм, журам, заавар мэдлэг дутмаг, мэргэжлийн ур чадвар дутмаг байдал 6 байна.

Үүнээс 23 алба хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 10 алба хаагчид сануулах, 3 алба хаагчийг тухайн албананд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулж, тухайн байгууллагын дотоод хяналтаар 17, гадны хяналтаар 2, иргэд, байгууллагаын мэдээллээр 17 зөрчлийг илрүүлсэн.

Цагдаагийн газрын алба хаагчдаас 2016 онд гэмт хэрэгт холбогдсон 3, захиргааны зөрчил гаргасан 2, алба хаагчдад явуулсан 21633001-21633040 хүртэл дугаартай 40 албаны шалгалтын мэдээг бичиж тухай бүр нь ДХШАБГ-т хүргүүлэн ажилласан.

Байгууллагаас 2015 онд 68 алба хаагчдад 52 албаны шалгалтыг явуулж байсан бол 2016 онд тус газрын алба хаагчдаас 60 алба хаагчдад 40 албаны

шалгалт явуулсан нь урьд оны мөн үеэс албаны шалгалтын тоо 12 буюу 23 хувиар, холбогдсон алба хаагчдын тоо 8 буюу 11.7 хувиар тус тус буурсан.

Алба хаагчдыг гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өртөж хохирсон талаар мэдэгдэх, сан бүрдүүлэх, ашиглах”, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” зэрэг сэдвүүдээр 4 удаагийн 4 цагийн сургалтыг зохион байгуулж, 2 удаа баталгаа авсан.

Газрын даргын зөвлөл 23 удаа хуралдаж үйл ажиллагааны чиглэлээр 42, хүний нөөцийн чиглэлээр 49, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 39, бусад асуудлын талаар 8 нийт 138 асуудлыг хэлэлцэн шийдвэрлүүлсэн.

Тасаг албад сар бүр хамт олны хурлыг зохион байгуулж, алба хаагчдынхаа ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн давхардсан тоогоор 126 алба хаагчийн сарын үндсэн цалинг тодорхой хэмжээгээр нэмж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн давхардсан тоогоор 63 алба хаагчийн сарын үндсэн цалинг тодорхой хувь хэмжээгээр хасаж олгосон.

Тайлангийн хугацаанд жагсаалын үзлэг, бэлтгэлийг 16 удаа явуулж, 35 зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засч арилгуулан, алба хаагчдын бэлэн байдлыг С-111 дохиогоор 1 удаа, тасгуудын бэлэн байдлыг хэсэгчилсэн байдлаар 4 удаа шалгаж, албаны бэлэн байдлыг ханггуулж ажилласан.

#### 6. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг

Тайлангийн хугацаанд эрүүгийн хэрэг, материалын шийдвэрлэлт, процессийн ажиллагаанд гарч байгаа хүндрэл бэрхшээл, алба хаагчдаас гаргаж байгаа алдаа дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар аймгийн Прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж хэвшсэн.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй урьд оны үлдэгдэл 29 гомдол мэдээлэл 2016 онд 1015 гомдол, мэдээлэл хүлээн авч нийт 1044 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгаснаас 31.4 хувь буюу 328 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 65.4 хувь буюу 683 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 0.3 хувь буюу 4 гомдол, мэдээллийг өөр орон нутагт харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн одоо 29 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд урьд оны үлдэгдэл 16 хэрэг, прокуророос шинээр дугаар авсан 352 хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 30 хэрэг, хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1 хэрэг бусад байдлаар хүлээн авсан 3 хэрэг нийт 402 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 166 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар, 136 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 62 хэргийг нэгтгэж, 3 хэргийг харьяаллын дагуу өөр орон нутгийн Цагдаагийн газарт шилжүүлж, 23 хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу түдгэлзүүлж шийдвэрлэн одоо 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Гэмт хэрэгт холбогдсон 23 эрүүгийн хэрэгт 28 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч шалгаснаас одоо хорьж мөрдөн хугацаа сунган шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч байхгүй.

Шийдсэн хэргээс яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явуулсан 106 хэрэгт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож арилгуулахаар мөрдөн байцаагчийн мэдэгдэл хүргүүлэн, 96 мэдэгдлийн хариуг авч ажилласан.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад 732.598.761 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 588.029.600 сая төгрөг буюу 80.2 хувийг нь нөхөн төлүүлж, эд хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор сэжигтэн, яллагдагчийн 563.230.000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Тус газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг нь бусад тасаг албадтай хамтран аймгийн хэмжээнд “САР ШИНЭ”, “ИЛРҮҮЛЭЛТ-2016”, “ИЛРҮҮЛЭЛТ-ШИЙДВЭРЛЭЛТ” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, “Түдгэлзүүлсэн хэргийг илрүүлж шийдвэрлэх чиглэлээр прокурорын байгууллагатай хамтарсан аян” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд газрын даргын тушаалаар алба хаагчдыг баг болгон хуваарилж ажиллуулснаар тухайн онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохиох этгээд нь тогтоогдоогүй 113 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 83 хэргийг илрүүлж, илрүүлэлт 73.4 хувь байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулвал 2.2 пунктээр өссөн.

2016 оны эхэнд ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1 дэх хэсэгт зааснаар түдгэлзүүлсэн хөнгөн ангиллын 5, хүндэвтэр ангиллын 57, хүнд ангиллын 1, онц хүнд ангиллын 2, ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 1, 205 дугаар зүйлийн 205.1.4 дэх хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 1, 205 дугаар зүйлийн 205.1.7 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 1 хэрэг нийт 68 хэрэгтэй.

Түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлж шийдвэрлэх чиглэлээр “САР ШИНЭ”, “ИЛРҮҮЛЭЛТ” нэгдсэн арга хэмжээ “ИЛРҮҮЛЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, “Түдгэлзүүлсэн хэргийг илрүүлж шийдвэрлэх чиглэлээр прокурорын байгууллагатай хамтарсан аян” зэргийг аймгийн хэмжээнд зохион байгуулж газрын даргын тушаалаар томилогдсон багуудад түдгэлзүүлсэн хэргүүдийг баг, сумдаар нь ялган хувиарлан ажилуулснаар 60 хэргийг сэргээн шалгаж 11 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 36 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 1 хэргийг өөр орон нутагт харьяаллын дагуу шилжүүлж шилжүүлж, 7 хэргийг нэгтгэж, 4 хэргийг буцаан түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Дээрх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулснаар урьд онд түдгэлзүүлсэн 8, энэ онд түдгэлзүүлсэн 7 хэргийг нөхөн илрүүлсэн нь 14.2 хувьтай.

ЭБШХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1.1-д заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн болон бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийг илрүүлэх зорилгоор шинээр бүртгэгдэн шалгагдаж байгаа хэргүүдийн холбогдогч нарын гарын мөрийг ШШҮХ-ийн гарын мөрний нэгдсэн санд тухай бүр оруулах ажлыг хэвшүүлж улиралын байдлаар **203** хүний гарын мөрний дардас санд орж баяжигдсан.

#### 7. Эрүүгийн цагдаагийн тасаг

Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажил, дотоод бичиг баримт, объектын судалгаа, бүртгэл, эрүү, хэв журам, замын хөдөлгөөний болон ГА-ын нөхцөл байдлыг судлах, гэмт хэрэг, зөрчил илрүүлэхэд хэрхэн ашиглах талаар 8 удаа 58 цагийн сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан. 2016 онд тасгийн алба хаагчид Гүйцэтгэх ажлын шугамаар нийт 210 мэдээ, мэдээлэл авч ГА-ын нэгдсэн тоо бүртгэлд оруулсан нь урд оны мөн үеэс 46 нэгжээр буюу 9.6 хувь өссөн.

Тайлант хугацаанд тасгийн алба хаагчид эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт 91 холбогдогчтой 173,7 сая төгрөгийн хохиролтой 84 материалыг шилжүүлж, 20 хэргийг нөхөн илрүүлж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас 45 материалд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас нийт 110 даалгавар, тогтоол хүлээн авч 106 даалгавар, тогтоолын хариуг өгч 4 даалгавар тогтоолын үлдэгдэлтэй байна.

Эрэн сурвалжлах ажлын чиглэлээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатнаас оргон зайлсан болон гэмт хэрэгт сэргэгдэн эрэн сурвалжлагдаж байсан 34 этгээдийг зарлан мэдээлж эрэн сурвалжлан, Улаанбаатар хот болон

бусад аймаг, сум, дүүргээс 8 оргодол, гэмт хэрэгт сэргэгдсэн 9 этгээд, шүүхээс эрэн сурвалжилсан 15 хүнийг тус тус олж баривчлан эрэн сурвалжлалтыг зогсоон одоо оргодол этгээд 1, гэмт хэрэгт сэргэгдсэн 1 этгээдийг эрэн сурвалжилж байна. Мөн ASAP санд нийт 57 эд зүйл, мал, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэг эрэн сурвалжлалт зарласнаас олж тогтоосон 23 эрэн сурвалжлалтыг зогсоосон.

#### 8. Нийтийн хэв журам хамгаалах тасаг

2016 онд захиргааны зөрчлийн шинжтэй нийт 7121 өргөдөл, гомдол хүлээн авч шалган шийдвэрлэж, гудамж талбай, олон нийтийн газар болон ахуйн хүрээнд иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж танхайрсан зөрчил гаргасан 855 хүнийг шийтгэврээр 10,195,000 төгрөгөөр, 1253 хүнийг торгуулийн тасалбараар 6,257,000 төгрөгөөр, шүүхээр 85 иргэнийг 7-30 хоногийн хугацаанд баривчлуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд хууль эрх зүйн талаар ухуулга, яриа таниулга, зөвлөгөө өгч ажилласан.

Давхардсан тоогоор нийт 2805 алба хаагч 362 удаа, 22440 цаг өдөр, оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 362 удаа эргүүл шалгалтанд ажилласан. Энэ хугацаанд 3815 тээврийн хэрэгсэл, 3456 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгаж ажилласан.

Тайлант хугацаанд Саатуулах байранд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, нийтийн хэв журам зөрчиж хүргэгдэн ирсэн 1766 хүнийг хүлээн авч, журмын дагуу бүртгэлд авч албадан saatuulж, 202 хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн дарга, цагдаагийн хурандаа Г.Эрдэнэцацralын 2016 оны 17/437 дугаар албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу галт зэвсэгийн нэгдсэн санг ашиглалтанд оруулсантай холбогдуулан аймгийн хэмжээнд бүртгэлтэй галт зэвсгийг apps.police.gov хаягаар санд шивж оруулах ажлыг тушаалаар ажлын хэсэг томилон үр дүнтэй зохион байгуулсан.

Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа "Бүрэн дуулга хонгор" ХХК, "Даяар хүч" хонгор секьюриты, "Барс" RMB ХХК, "Шонхор", Бөмбөгөр арвижих ХХК гэсэн 4 гэрээт харуул хамгаалалтын албаны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулж, харуул хамгаалалтын албаны судалгааг хийж, улирал бүр мэдээ тайланг авч ажилласан. Шинээр Мөнхболд жигүүр ХХК-ний "Шонхор" харуул хамгаалалтын алба нь хүсэлтээ гаргаж материалаа ирүүлснийг шалгаж, Цагдаагийн газрын даргын 05 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон.

Баянхонгор аймагт Монгол УИХ-ын дарга 3.Энхболд 2016 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл ажиллах үеийн хэв

журмын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтыг батлагдсан төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулж, хэв журмын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтад 15 офицер, 16 цагдаа, 3 автомашин, 4 мотоцикл, 18 станц ажиллан, хамгаалалтын үйл ажиллагааг зөрчилгүй зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд “Говийн бүс”, “Хангайн бүс”, “Төвийн бүс”, “Номгон хайрханы их хурд” хурдан морины хамгаалалтуудыг төлөвлөгөө, зураглалын дагуу 15 офицер, 28 ахлагч бие бүрэлдэхүүний хүчээр зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 7/1191 дугаартай тушаал, аймгийн Онцгой комиссын даргын 2016 оны 01 тоот тушаалыг үндэслэн гамшгаас хамгаалах бэлтгэл ажлыг хангуулах сургалт, дадлагын ажиллагааг зохион байгуулав.

2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 16 цаг 00 минутад Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиог хүлээн авч, Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүний гамшиг, ослын үед ажиллах алба хаагчдын мэдлэг, ур чадвар, албаны бэлтгэл, бэлэн байдлыг аймгийн Онцгой комиссийн гишүүд шалгаж зөрчилгүй гамшгийн сургалтад хамрагдсан.

Аймгийн Засаг даргын А/18 тоот захирамжаар “Бoom” өвчин гарсантай холбогдуулан хүн, малын хорио цээрийн дэглэм тогтоож, голомтын бүсэд сумын төвийн баруун, зүүн талын зам орох, гарах зам дээр байнгын постыг 7 хоногийн хугацаанд гарган ажиллуулсан.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг банкны салбар, тооцооны төвүүдийг шалгах төлөвлөгөө гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбартай хамтран хяналт шалгалт явуулж, тус аймагт үйл ажиллагаа явуулдаг Хаан банкны 4 салбар, Голомт банкны 3 салбар, Капитал банкны 2 салбар, Төрийн банкны 2 салбар, Хас банкны 2 салбар хамрагдаж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу банкуудын төле хяналтын камерын ажиллагааг шалгаж, нийт 13 салбар, тооцооны төвүүдийн ажилтан, алба хаагч нарт аюулгүй байдлын чиглэлээр 2 цагийн сургалтыг Монголбанктай хамтран явуулсан.

Монгол Улсын Их Хурал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны сонгуульд нэр дэвшиж байгаа улс төрийн намуудын сурталчилгааны нээлт, сонгуулийн үеийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж хамгаалалтыг батлагдсан төлөвлөгөө зураглалын дагуу зохион байгуулсан.

Тус аймгийн 104 хэсгийн хорооны санал авах байрны хамгаалалтыг зөрчил, дутагдалүй зохион байгуулж, Улаанбаатар хотоос нэмэгдлээр ирж ажилласан 23 алба хаагчийн “Сонгогч шилжих хуудас”-ыг хүлээн авч, Баянхонгор сумын 11 сонгуулийн хороонд хамгаалалтанд ажиллах алба хаагчдыг сонгууль өгөх эрхээр нь хангасан.

#### 9. Замын цагдаагийн тасаг

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, нас барсан болон гэмтсэн хүн, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцөл зэрэгт дүн шинжилгээ, судалгаа хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулах зорилгоор иргэд, жолооч нарын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион явуулсан.

Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, зам тээврийн осол, хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Мэргэжил хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сумын байгаль орчны улсын байцаагч настай хамтарч, “Сар шинэ”, “Илрүүлэлт” “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр” зэрэг сэдэвт 22 төрлийн нэгдсэн арга хэмжээг бусад албад, тасагтай хамтран зохион эргүүл шалгалтыг явуулж, орон нутгийн “Хөгжлийн ертөнц ТҮ-10”, “Хонгор” телевизид 28 удаа сэрэмжлүүлэг, мэдээлэл явуулсан.

Энэ онд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 19 бүртгэгдэж, 8 хүний амь нас хохирч, 16 иргэнд хүндэвтэр гэмтэл учирсан. Хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, тогтоомж журам зөрчиж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 863, эрхийн үнэмлэхгүй жолоодсон 483, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 96, хамгаалах бүс хэрэглээгүй 589, хамгаалалтын малгай хэрэглээгүй мотоцикл жолоодсон 117, бусад зөрчил 215-ийг нийт 4041 зөрчил илрүүлэн ажилласан.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 701 захиргааны зөрчил шалгаснаас 639 жолоочийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жилийн хугацаагаар хасч, цаашид хөдөлгөөнд үргэлжлүүлэн оролцох боломжгүй 1454 тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаанд саатуулсан.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчиж зөрчил гаргасан нийт 4215 тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 320,616,800 төгрөгөөр торгож, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Бууцагаан, Жаргалант, Баянлиг, Богд зэрэг 17 суманд хууль сурталчилан ажилласны дүнд

өнгөрсөн оны мөн үеийнхээс Хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 13,3 хувиар буурсан.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар 17.2-т заасан тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэхний хүчинтэй хугацаа дууссан 1240 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхний материалыг бүрдүүлэн мөнгө тушаасан баримтын хамт, Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн хугацаа нь сэргэсэн 214, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхээ үрэгдүүлсэн болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, хугацаа нь дуусан шалгалт өгч тэнцсэн 300 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг дахин авахаар материалыг ЦЕГ-ын Лицензийн төвд хүргүүлсэн.

Баянхонгор аймагт гарч буй Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын талаар иргэд олон нийтэд сээрэмжлүүлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг сурталчилах чиглэлээр олон нийтийн байгууллага иргэдтэй хамтран “Эрчим хүч түгээх газар”, 7 дугаар цэцэрлэг, “Номундалай” ахлах сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, “Чандмань” ХХК, Онцгой байдлын газар, 339 дүгээр цэргийн анги зэрэг байгууллагуудын ажилтан алба хаагч наарт сургалт орсон.

Мөн Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Боловсрол соёлын газартай хамтран Цагдаагийн байгууллагын 95 жил, Замын цагдаагийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийг ойг тохиолдуулан “Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Замын хөдөлгөөн-хүүхэд” сэдэвт хэлэлцүүлэг зөвлөгөөнийг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр тус аймагт зохион явуулж, “Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарах асуудал”, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сурган хүмүүжүүлэгч нарын оролцоо” сэдвээр итгэл, мэдээлэлүүдийг тус тус хийсэн.

Арав. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс  
урьдчилан сэргийлэх чиглэлээр

Ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагууд, нийгмийн ажилтан настай байнгын холбоотой ажиллаж, ерөнхий боловсролын 6 сургуулийн сурагчдад гэр бүлийн хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, уршгийн талаар сургалтыг Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, сургуулийн нийгмийн ажилтан настай хамтран давхардсан тоогоор нийт 1240 сурагчдад 4

удаагийн сургалт, мэдээллийг хийсэн. Мөн аймгийн Бөмбөгөр, Жаргалант сумдад зохион багуулагдсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний үеэр ерөнхий боловсролын сургуулийн сургачид, сургуулийн нийгмийн ажилтан, Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагч, сумын иргэдэд мэдээлэл, сургалт, тус сумын ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах бүлгийн 54 сургачдын дунд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-аар АХА тэмцээнийг явуулсан.

Хүүхдийг аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сургачдын аюулгүй суралцах орчинг бүрдүүлэх, тэднийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эхчүүдийг татан оролцуулах зорилгоор “School police” төслийг аймгийн хэмжээнд 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажилласан. Мөн аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Баянхонгор аймаг дахь салбартай хамтран хүүхэд хамгааллын хамтарсан багуудын “Хүүхдийн төлөө хамтдаа” чуулганыг 2 удаа зохион байгуулж, уг чуулганаар гэр бүл, хүүхдийн сайн сайхны төлөө, тэдний бүх талын хэрэгцээнд зориулсан аюулгүй хайрын орчинг бий болгоход чиглэсэн сургалтыг орон нутгийн түншлэлийн багийн гишүүдэд орон нутгийн сургагч багш бэлтгэх, тэдгээрийг ур чадварыг дээшлүүлэх сургалт, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 148 дугаар тогтоолыг гаргуулж, 2015-2016 оны хичээлийн шинэ жилд “Сургуулийн цагдаа эргүүл”-ийн журмыг ерөнхий боловсролын 25 сургууль дээр хэрэгжүүлж, үр дүнг тооцож, шалган зааварчилж ажиллалаа. Эцэг, эхчүүдийг хуваарьт оруулан сургуулийн орчинд эргүүл хяналт шалгалтыг явуулж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр 5 удаа сурталчилж ажиллав. 2015-2016 оны хичээлийн шинэ жилийн хүрээнд журмыг сайн хэрэгжүүлсэн сургуулийг тогтоож, урамшуулахаар шийдвэр гаргуулан ажиллалаа. 2016 оны 4 дүгээр улиралд “School police” арга хэмжээг иргэдэд сурталчлах чиглэлээр Баянхонгор сумын ерөнхий боловсролын сургуулийн сургачдын эцэг, эхчүүдийн дунд “Дэвжээ” тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Энэ тэмцээнийг зохион байгуулснаар иргэдэд сургуулийн цагдаа эргүүлийн үйл ажиллагааг сурталчилсан, эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдсэн.

Тус газраас 2016 оны 4 дүгээр улиралд ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн сургачдыг цуглуулан 5 өдрийн сургалтыг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран зохион байгуулсан. Энэ сургалтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилсан.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Баянхонгор Дэлхийн ЗӨН, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Завхан, Баянхонгор аймгуудын Хангайн бүсийн “Хүүхдэд ээлтэй орон нутаг-хүүхдийн оролцоо” сэдэвт туршлага солилцох чуулганыг аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран 2016 оны 09 дүгээр сарын 15-наас 18-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Хүүхдийг аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сургуулийн цагдаа” эргүүлийн журмыг батлуулан сургуулиуд дээр эцэг эхчүүдийг эргүүлд гарган ажиллуулснаар сургуулийн орчимд гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.

Арван нэг. Санхүү, нийгмийн асуудлын талаар авсан  
арга хэмжээний үр дүн

Тус газар нь 2016 онд 1,754,985,300 төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 59,792,000 төгрөг оруулж, санхүүгийн үйл ажиллагаандaa Монгол Улсын Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам” бусад холбогдох хууль, журмыг үйл ажиллагаандaa мөрдөн ажилласан. Тайлант хугацаанд цалин, НДШимтгэлд 1,609,868,000 төгрөг, тогтмол зардал болох Түлш халаалтын зардалд 14,684,000 төгрөг, гэрэл цахилгааны зардалд 12,986,300 төгрөг, цэвэр бохир усны зардалд 5,052,000 төгрөг, шатах тослох материалын зардалд 72,007,837 төгрөг, шуудан холбооны зардалд 6,907,800 төгрөг, алба хаагчдын дотоод албан томилолтын зардалд 12,699,000 төгрөг, бичиг хэргийн зардалд 13,069,180 төгрөг, урсгал засварын зардалд 6,966,300 төгрөг, хоолны зардалд 17,879,900 төгрөг, хөдөлмөр хамгаалалын хэрэгслийн зардалд 757,500 төгрөг, эмийн зардалд 745,100 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 2,051,100 төгрөг, даатгалын хураамжийн зардалд 3,350,600 төгрөг, хичээл үйлдвэрлэл болон сургалтын зардалд 250,200 төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардалд 1.500.000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11,249,711 төгрөгийг тус тус зарцуулж нийт 1,814,773,300 төгрөгийн зардалтай ажилласан.

Байгууллагын 2015 оны жилийн эцсийн байдлаар нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг сангийн яам татан төвлөрүүлсэнтэй холбоотой 2,752,100 төгрөгийн авлага үүссэн байсныг 3 дугаар сард сангийн яам буцаан олгож авлага барагдсан.

2015 оны жилийн эцсийн байдлаар 6.063,500 төгрөгийн өглөгтэй ажилласнаас өглөг барагдаж, өглөггүй ажиллаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулж, Сангийн сайдын 73 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахаар 7.000.000 төгрөгийн зардлын тооцоог гаргаж, хүсэлтийг ЦЕГ-ын СХГазарт хүргүүлэн ажилласан.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилон 3 удаа тоолж, хөрөнгө актлуулах, орлогот авах болон бусад асуудлыг өмч хамгаалах зөвлөлөөр 11 удаа, газрын даргын зөвлөлийн хурлаар 3 удаа хэлэлцүүлж, элэгдлээрээ өртөгөө нөхсөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу аймгийн ИТХТ-д хүсэлт уламжилж шийдвэрлүүлэн, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 4.702.558 төгрөгийн техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 13 нэр төрлийн автомашиныг Үнэлгээний хороогоор үнэлүүлэн актлуулах санлыг Орон нутгийн өмчийн албанад хүргүүлэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 23 дугаар тогтоолоор актлаж, данс бүртгэлээс хасаж бүртгэсэн.

Санхүүгийн програмыг үйл ажиллагаандaa иж бүрэн ашиглан тухай бүр мөнгөн хөрөнгө, холбогдох журналуудыг хөтлөн няраваар сар бүр тайлан гаргуулан ОУНББ-ын стандартад нийцүүлэн ажиллав. Сар бүрийн төсөвт зардлын гүйцэтгэлийн мэдээ болон хүсэлт баталгаа, НДШ-ийн тайлан, татварын болон санхүүгийн тайлангуудыг хуулийн хугацаанд үнэн зөв гарган ЦЕГ-ын СХГазар болон Аймгийн Төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст тус тус гаргаж хүргүүлж, алба хаагчидтай өдөр бүр үнэт цаасны тооцоо хийж, үнэт цаасны тайланг дараа сарын 5-ны дотор гаргаж, ЦЕГ-ын СХГ-т тухай бүр нь хүргүүлсэн. ЦЕГ-ын даргын 2013 оны 218 дугаар тушаалын дагуу жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад болон бусад шаардлагатай үед газрын цайны газартай гэрээ байгуулан хоолоор хангаж, хоолны мөнгийг тухай бүр шилжүүлж ажилласан.

Мөн ЦЕГ-ын хангальт, үйлчилгээний төвөөс тусгай хэрэгсэл, алба хаагчийн өвөл, зуны хувцасны хангальт, Санхүү хангамжийн газраас согтуурал хэмжигч багаж хэрэгслүүдийг тус тус хүлээн авч хөрөнгөнд бүртгэлээ.

Төсвийн орлого зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, төсвийн орлого ба зарцуулалтын мэдээ, тайлангуудыг хугацаанд нь гаргаж, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг хэрэгжүүлэн сар болгон холбогдох мэдээ мэдээллүүдийг шинэчлэн, тухай бүр шилэн дансны <http://shilendans.gov.mn/> сайтад нийт 120 мэдээ,

мэдээлэл оруулж байршуулсан. Мөн Цагдаагийн газрын “Иргэдийн хүлээлгийн танхим”-д байрлах мэдээллийн самбарт байршуулан сурталчилан ажилласан. Санхүүгийн 2015 оны тайлан балансыг аймгийн Төрийн аудитын газраас шалгуулж, зөрчилгүй санал дүгнэлтийг авч, байгууллагын үндсэн хөрөнгүүдийн бүх мэдээллийг Төрийн өмчийн [www.spc.gov.mn](http://www.spc.gov.mn) сайтын Төрийн болон орон нутгийн Өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд байршуулсан.

Санхүүгийн мэдээллүүдийг байгууллагын ил тод байдлыг харуулсан самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон өөрийн байгууллагын цахим хуудсанд 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2016 оны батлагдсан төсвийн хуваарь, төсвийн эрх захирагчийн гүйцэтгэлийн хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, хүрсэн үр дүн, худалдан авах ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил, гүйлгээ, санхүүгийн тайлангууд, байгууллагын өмч хөрөнгөтэй холбогдон гарсан тушаалуудыг цахим байдлаар болон файл хэлбэрээр байршуулан ажиллалаа.

Арван хоёр. Үнэт цаас болон бусад тооцооны талаар

2015 оны жилийн эцсийн байдлаар 2394 ширхэг торгуулийн тасалбар, 1568 ширхэг шийтгэврийн үлдэгдэлтэй ажилласнаас тайлант хугацаанд нийт 1000 ширхэг шийтгэвэр, торгуулийн хуудсыг Санхүү хангамжийн газраас хүлээн авч, 2028 ширхэг торгуулийн хуудас, 1391 ширхэг шийтгэврээр нийт 126.661.500 төгрөгийн орлогыг орон нутгийн хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлэн ажилласан.

Галт зэвсгийн гэрчилгээ оны эхэнд байгууллагын хэмжээнд 45 ширхэгийн үлдэгдэлтэй байснаас Санхүү хангамжийн газарт галт зэвсгийн гэрчилгээний тайланг хүргүүлэн гэрчилгээний тооцоог бүрэн хийж дуусган, 100 ширхэг гэрчилгээг СХГ-аас шилжүүлэн авч, орлогоор бүртгэсэн.

Тээврийн хэрэгсэл түр saatuuлах байрны төлбөр төлөлтийн тооцоог сар бүр тулгаж баталгаажуулан нийт 4.935.000 төгрөг, saatuuлагдсан болон баривчлагдсан хүмүүсийн төлбөр төлөлтөнд хяналт тавьж, сар бүр тайланг хүлээн авч харилцахын хуулгатай тулган баталгаажуулж нийт 7.729.650 төгрөгийг байгууллагын 030012001 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан.

Монгол банкны гэрээт цагдаагаар ажиллаж байгаа 4-н алба хаагчийн цалин хоолны зардлын тооцоог гаргаж, Монгол банкинд хүргүүлэн шийдвэрлүүлж, 23,911,851 төгрөгийг байгууллагын 030012001 тоот дансанд төвлөрүүлсэн.

Арван гурав. Алба хаагчдын нийгмийн хамгааллын талаар

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны 5 хувийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан алба хаагчдад банкны ажилтнуудаар 6 удаа мэдээлэл хийлгэн, орон сууцны зээл авахад бүрдүүлбэл зохих холбогдох материал тодорхойлолтыг байгууллагын зүгээс гарган өгч, аймгийн Засаг даргаас алба хаагчдыг орон сууцтай болгоход 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсний дагуу хүсэлт гаргасан 18 алба хаагчийн материалыг холбогдох банкуудад хүргүүлэн, ипотекийн зээлд хамрагдах боломжтой эсэхийг судлуулан шаардлага хангасан 10 алба хаагчийг урьдчилгаа төлбөргүйгээр хямдралтай үнээр “Зүүн шанд” ХХК-тай гэрээ байгуулан 2016 оны 06 дугаар сарын 08-нд ашиглалтад орсон 25-н айлын орон сууцанд оруулсан.

Байгууллагын алба хаагчдаас 2015 онд төлсөн татварын хөнгөлөлтийн буцаан олголтыг тооцож, 20 алба хаагчдад 17, 837,090 төгрөг олгож, ердийн галлагаатай хашаа байшин болон гэрт амьдардаг 23 алба хаагчдад тус бүр 2 тн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр, 14 ахмад настанд тус бүр 2 тн нүүрс үнэгүй нийт 74 тн нүүрсийг олгож, 2 ахмад настанд 408,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлсэн.

Алба хаагчдын цалинг энэ онд ажлын үр дүн, олон нийтийн ажил, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон зэргийг харгалзан газрын даргын тушаалын дагуу нийт 2 алба хаагчдын цалинг 1,5 дахин, 124 алба хаагчдын цалинг 5-30 хувь хүртэл нэмж, нийт 41.754.943 төгрөг олгосон бол, 57 алба хаагчдын цалинг 5-20 хүртэл хувиар тооцож 7,124,043 төгрөгийг хасаж цалинг олгосон.

Тус газар нь “Баянхонгорын хөгжил” төрийн бус байгууллагатай хамтран 68 алба хаагчийн хүүхдэд хайрын бэлэг гардуулах арга хэмжээг зохион байгуулав.

Ахмадын сан нь 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 2,222,600 төгрөгийн зардал зарцуулж, цагаан сарын баярын хүлээн авалт, хүндэтгэлийн арга хэмжээ гарын бэлгэнд 1,520,600 төгрөг, ахмад настнуудыг Улаанбаатар хотод Цагдаагийн байгууллагын удирдлагууд хүлээн авч уулзах уулзалтанд оролцох ахмад настнуудын ирж, буцах замын зардал болон буудлын зардалд 522,000 төгрөг, Шаргалжуутын амралтын байрны тохижилтын ажилд 180,000 төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ онд бие бүрэлдэхүүний дундын сангаас нийт 10,539,000 төгрөг зарцуулсан. Үүнээс алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 5,477,000 төгрөг, соён гэгээрүүлэх ажилд 2,130,000 төгрөг, бусад асуудалд 2.932.000 төгрөгийг тус тус зарцуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдын хамт олны “Дундын сангийн журам”-ын 6-д зааснаар “Зайлшгүй шаардлагатай тохиолдолд сард 3 хүртэл алба хаагчид 1 сарын

хугацаатай 500000 хүртэлх төгрөгийг 3 хувийн хүүтэй дундын сангаас гаргаж, дундын санд хуримтлал бүрдүүлэх” гэсэн заалтын дагуу 38 алба хаагчид 11,078,000 төгрөгийг сарын 3 хувийн хүүтэй зээлүүлж эргэн төлүүлсэн.

Мөн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд Өлзийт сумын “Бумбат” гэх газар 1га тариалангийн талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 4 тонн төмс, хүнсний ногоо хурааж алба хаагч нарт хуваарилж өгсөн.

Алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэн, урамшуулж, нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх зорилгоор Дорноговь аймгийн “Хамрын хийд”, “Энергийн төв” Хөвсгөл, Архангай, Булган, Орхон аймаг болон БНХАУ-ын “Эрээн” хот, аялуулах арга хэмжээг зохион байгуулж, 24 алба хаагчийг хамруулсан.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойн хүрээнд залуу гэр бүлийг дэмжих зорилгоор аймгийн төвд өмчлөлийн газраа авч чадаагүй байсан 10 алба хаагчид эзэмшлийн газар олгуулж, 2015 оны төсвийн урамшууллаас хашаа барихад нь зориулж 400 ширхэг банзыг хямдралтай үнээр авчирч хашаа бариулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Ахмадын холбооны дарга, бэлтгэл хурандаа Л.Билгээ, тус газрын даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл хурандаа С.Саадэлэг, бэлтгэл хурандаа Ц.Даваадорж, бэлтгэл хурандаа Х.Рэгсүрэн, бэлтгэл хурандаа Я.Цагаанчулуун, цагдаагийн хурандаа Д.Мөнхбаяр нарыг урьж, “Ахмадуудаасаа суралцаж, сонсьё” сэдэвт уулзалт арга хэмжээг хурлын танхимд зохион байгуулж, нийт алба хаагчид, ахмад настнуудыг оролцуулсан нь үр дүнтэй болсон.

Тус газраас Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 95 жил, Мөрдөн байцаах алба үүсч хөгжсөний түүхт 70 жилийн оиг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/302 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагч, ажилтаны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Баттөмөр, Н.Түмэннасан, цагдаагийн дэслэгч Б.Батцэнгэл, эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад С.Анхбаяр нар хуримын ёслолын үйл ажиллагаагаа “Гэрлэх ёслолын ордон”-д Намрын дунд сарын билэгт сайн өдөр ёслол төгөлдөр явууллаа.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Монгол улсад “Вируст хепатиттай тэмцэх” үндэсний арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл элэг” хөтөлбөрийг байгууллага дээрээ хэрэгжүүлж, элэгний В, С вирус тоолох шинжилгээнд 2 удаа давхардсан тоогоор 148 алба хаагчийг хамруулж, цаашид хэрхэн эмчлүүлэх талаар нарийн мэргэжлийн эмчээр зөвлөгөө өгүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 930.5/-д заасны дагуу төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж яваад алтан амия алдсан гавьяат үйлстэн, цагдаагийн хошууч П.Энхмөнх агсныг дурсаж, түүний алдар гавьяаг мөнхжүүлэх хүндэтгэлийн “Бид мартахгүй” арга хэмжээг 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Газрын даргын санаачлагаар орон нутгийн “Хөгжлийн ертөнц ТҮ-10” телевизтэй хамtran цагдаагийн хошууч П.Энхмөнх агсны хүүхэд нас, сургуульд орж, төгссөн үе, аж амьдрал, намтар түүхийг харуулсан богино хэмжээний 20 минутын баримтат кино бүтээж, дэлгэцээр үзүүлж, тайлбар хийж танилцуулсан. Аймгийн Биеийн тамир, спорт хорооны зааланд цагдаагийн хошууч П.Энхмөнх агсны нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг тус газрын тасгуудын дунд амжилттай зохион байгуулж, цагдаагийн хошууч П.Энхмөнх агсан болон түүний гэр бүлийн гишүүдэд хүндэтгэл үзүүлж, бүх алба хаагчид түүнийг эргэн дурсаж, хүндэтгэл үзүүлэн “Бид мартахгүй” арга хэмжээний талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлан ажилласан.

Энэ онд хамт олны хурлын шийдвэрээр амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 1, өөр аймгаас ЦЕГ-ын даргын тушаалаар томилогдон ирсэн 2 алба хаагчийг албаны орон сууцаар хангасан.

Тус газраас Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хууль зүйн сайдын 2013 оны А/271 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 2.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн тангараг өргөх ёслол” журам /код 905/-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд газрын даргын 2016 оны А/184 дүгээр тушаалаар “Цагдаагийн тангараг өргөх” арга хэмжээг 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 11<sup>40</sup> цаг /морин цаг/-т Цагдаагийн газрын урд жагсаалын талбайд ёслол төгөлдөр зохион байгуулж, тус газарт шинээр томилогдон тангараг өргөөгүй ажиллаж байгаа нэр бүхий 12 алба хаагчдаар тангараг өргүүлсэн.

**ТАЙЛАН ГАРГАСАН:**  
**ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАСГИЙН ДАРГА,**  
**ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА** **Б.БАТБИЛЭГ**

**ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:**  
**ДАРГА,**  
**ЦАГДААГИЙН ХУРАНДАА** **Б.ОЮУТБОЛД**